

УУЛ УУРХАЙН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН АКТЫН БИЕЛЭЛТ

(2016 оны жилийн эцсийн байдлаар)

Дуг аар	Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар, заалт	ХБ, ХБЗХ	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө	Үнэл гээ
НЭГ. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО				
МУ-ын хууль				
1	ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ 2014-01-09 3.3 Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж байна.	ГБГ	Гацууртын ордын төрийн эзэмшлийн 34 хувийг АМНАТ тусгай төлбөрийн хувийн 3 хувиар орлуулахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.	/-/
2	МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 2015-02-18 47.2 .Энэ хуулийн 472.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална.	БХЗГ	Стратегийн ач холбогдол бүхий Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж байна. Биелэлт 70%.	70%
УИХ-ын тогтоол				
1	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний туха 2009-07-16 1.2 Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн заагийн дотор үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ашигт малтмалын тухай болон байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах	БХЗГ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран хяналт, шалгалтын дагуух санал дүгнэлтийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж, 2015 оны 02 сарын 18-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлж, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг батлуулсан. Биелэлт 100% Хаах саналтай байна	100 %

2	2	<p>Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай 2014-01-16</p> <p>2."Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай: 1/"Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ын зарчим, зорилтод нийцүүлэн эрдэс баялгийн салбарын холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулан хэрэгжүүлэх; 2/"Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-д тусгасан зорилт, чиглэлийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, төрийн мөнгөний бодлого, дунд, урт хугацааны төлөвлөлтөд тусгуулан хэрэгжүүлэх.</p>	ГБГ	<p>1. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ын зарчим, зорилтод нийцүүлэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн УИХ-ын чуулганаар батлуулсан.</p> <p>2. "Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-д тусгасан зорилт, чиглэлийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл болон урт, дунд хугацааны хөтөлбөрт тухай бүр тусган ажиллаж байна.</p> <p>Биелэлт-100%</p>	100 %
---	---	---	-----	---	-------

Ерөнхийлөгчийн зарлиг

1	1	<p>Ажлын хэсэг байгуулах тухай 2013-03-07</p> <p>2 Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Ажлын хэсгийн дарга: Д.Ганхуяг-Уул уурхайн сайд Дэд дарга: Ч.Өнөрбаяр-Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх Гишүүд: Р.Жигжид-Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Бат-Эрдэнэ-Уул уурхайн сайдын зөвлөх О.Цэндсүрэн-ҮАБЗ-ийн Ажлын албаны дарга Ч.Отгочулуу-Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Батхүү-Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Жавхланболд-Уул уурхайн яамны Хяналт-шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Жавхланбаатар-ЭЗХЯ-ны Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газрын дарга Г.Алтансүх-Ашигт малтмалын газрын дарга Л.Болдхүү-УУЯ-ны Төрийн захиргааны удирдлагын</p>	УУБГ	"Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого"-ыг 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар батлагдсан. Хаах саналтай байна	100 %
2	2	<p>Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элмент, газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тухай 2015-05-19</p> <p>2 Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элмент, газрын тосыг ашиглахтай холбогдсон бодлогын асуудлыг ҮАБЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж байхыг Засгийн газарт чиглэл болгосугай.</p>	БХЗГ	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 77 дугаар зарлигаар 1995 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 39 дүгээр зарлигийг хүчингүй болгосноор газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг ҮАБЗ-д танилцуулан зөвлөмж гаргуулах шаардлагагүй болсон.	100 %

2	3	<p>Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элмент, газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тухай 2015-05-19</p> <p>3 Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элментийн хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл олгох, эрх шилжүүлэх, мөн газрын тосны хайгуулын бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлж байхыг төрийн холбогдох байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.</p>	БХЗГ	<p>Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох тухай асуудлаар Засгийн газрын хуралдаанаар Арева Монгол ХХК, Мон-Атом ТӨХК нарын хамтарсан компани Арева майнз ХХК, мөн Гурвансайхан ХХК-д ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг олгох талаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.</p> <p>Засгийн газрын хуралдаанаар БХГ-тэй холбоотой асуудлыг тухай бүр хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байна. 2015 онд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар сонгон шалгарсан Газрын тосны хайгуулын Увс-1, Хэрлэн тохой-XXVIII, Хар-Ус II талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах эрх олгох асуудлыг Засгийн газрын 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн болон 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулж, №162, №246 тогтоолоор батлуулсан. Газрын тосны хайгуулын “Богд IV” ба “Онги V” талбайд Газрын тосны газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Сентрал азиан петролеум корпорэйшн лимитэд” ХХК-ийн бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүлээсэн гэрээлэгчийн эрх, үүргийг “BG Mongolia holdings limited” компанид хэсэгчлэн шилжүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 172 дугаар тогтоолоор батлуулсан. Газрын тосны хайгуулын “Номгон IX” талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргийг шилжүүлэх тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулан Засгийн газрын 2015 оны 300 тоот тогтоолоор шийдвэрлүүлсэн. Түүнчлэн Засгийн газрын 2015 оны 431 дүгээр тогтоолоор газрын тосны хайгуулын Тариач-XV талбайд байгуулсан БХГ-г цуцлах асуудлыг тус тус батлуулсан.</p> <p>Биелэлт-100%</p>	100
ЗГ-ын тогтоол					
1	1	<p>Талбай нөөцөд авах, хайгуулын ажил хийх тухай 2012-11-10</p> <p>2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан талбайд “Эрдэнэс МГЛ” ХХК-иар дамжуулан геологи хайгуулын ажил хийх асуудлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Ашигт малтмалын газрын дарга Г.Алтансүх, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд даалгасугай.</p>	ГБГ	2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын 214 дүгээр тогтоолоор нөөцөд авсан талбайг чөлөөлж, уг тогтоолыг хүчингүй болгосон. /хаах саналтай./	/-/
2	2	<p>Талбай нөөцөд авах, хайгуулын ажил хийх тухай 2013-03-16</p> <p>2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан талбайд “Эрдэнэс МГЛ” ХХК-иар дамжуулан геологи хайгуулын ажил хийх асуудлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Ашигт малтмалын газрын дарга Г.Алтансүх, Төрийн өмчийн хороо (Д.Цогтбаатар)-нд даалгасугай.</p>	ГБГ	Талбайг нөөцөөс чөлөөлөх тохиолдолд асуудлыг холбогдох байгууллагуудтай ярилцаж, судалж шийдвэрлэх тул тухайн үед нь Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.	/-/
3	3	<p>Журам батлах тухай (түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам) 2014-07-09</p> <p>2 Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн сайд А.Гансүх, Уул уурхайн сайд Д.Ганхуяг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.</p>	ГБГ		/-/

4	4	<p>Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай 2014-08-20</p> <p>1.б Хөрөнгө оруулагч нь Баруун болон Зүүн Цанхийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайд нүүрс олборлох, тэдгээр талбайд нэмэлт хайгуул хийж нөөцийг нэмэгдүүлэх;</p>	УУБГ	<p>“Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн зарчим, удирдамж батлах тухай” УИХ-ын 2008 оны 40 дүгээр тогтоол, “Тавантолгойн ордыг ашиглах зарим асуудлын тухай” УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолуудыг удирдлага болгон Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын дагуу Тавантолгойн ордод хөрөнгө оруулж, хамтран ашиглах Хөрөнгө оруулалтын болон бусад дагалдах гэрээний төслүүдийг УИХ-аар хэлэлцүүлэхээр Засгийн газраас өргөн барьсан.</p> <p>Улсын Их Хурлын даргын 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 101 дүгээр захирамжаар “Тавантолгойн нүүрсний ордыг хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Тавантолгойн ордыг хөгжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ болон хавсралт гэрээнүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэгээр ахлуулан байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд: УИХ-ын гишүүн Су.Батболд, Д.Ганхуяг, А.Бакей, О.Баасанхүү, М.Сономпил, С.Ганбаатар, Д.Сумъяабазар, Б.Чойжилсүрэн, Б.Наранхүү нар орсон.</p> <p>Тус Ажлын хэсэг “Тавантолгойн ордтой холбоотой гэрээ нь тухайн асуудлаар гарсан УИХ-ын болон холбогдох Байнгын хороодын тогтоолтой нийцэж байгаа эсэх”, “Гэрээ нь Үндэсний Аюулгүй байдлын Үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн Зөвлөмж, Засгийн газрын холбогдох шийдвэр болон төрийн эрх бүхий байгууллагын бусад шийдвэртэй нийцэж байгаа эсэх”, “Гэрээ нь Монгол Улсын баримталж буй гуравдагч хөршийн бодлоготой нийцэж байгаа эсэх”, “Эрдэнэс Тавантолгой” ХК-д 1072 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа иргэд болон үндэсний аж ахуйн нэгжүүдийн эрх ашгийг хангаж байгаа эсэх” зэрэг нийт 14 зүйл заалт бүхий удирдамжийн хүрээнд санал, дүгнэлт гаргах юм.</p> <p>Тавантолгойн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээ, Хамтын ажиллагааны гэрээ, Концессын гэрээний төслүүдэд Уул уурхайн яамнаас Ажлын хэсэгт оролцсон төлөөлөл саналаа өгч байсан бөгөөд дээрх Ажлын хэсэгт ч холбогдох саналаа хүргүүлсэн болно.</p> <p>Тавантолгойн ордын хөрөнгө оруулагч талууд /БНХАУ-ын Шиньхуа Энержи, Монголын Энержи Ресурс болон Японы Сумитомо корпораци/-тай байгуулах гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийн хэлэлцээний явц, үр дүнг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байна. Мөн УИХ-ын 40 гаруй гишүүд “Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах тухай” Улсын Их Хурлын</p>	70
5	5	<p>Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай 2014-09-18</p> <p>3.3. Улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг ашигт малтмалын кадастрын болон газрын кадастрын мэдээллийн сангийн бүртгэлд бүртгэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Уул уурхайн сайд Д.Ганхуяг нарт даалгасугай.</p>	ГБГ	<p>Улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг ашигт малтмалын кадастрын бүртгэлд бүртгэж авсан. Биелэлт-100% Хаах саналтай байна.</p>	100 %
6	6	<p>Алт олборлолтыг нэмэгдүүлж, эдийн засгийн эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2015-03-11</p> <p>3 Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай:</p> <p>3.1. гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам болон гэрээний загварыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, 2015 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газрын хуралдаанд оруулж батлуулах;</p> <p>3.2. усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалттай бүсийн хилийн заагийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шуурхай тогтоох;</p> <p>3.3. ашигт малтмалын нөөцийн тодотгол, техник,</p>	БХЗГ	<p>БОНХАЖ-ын Сайдын 2015 оны 04 сарын 21-ны өдрийн А-185 тоот тушаалаар Хилийн заагын тодорхойлолт гаргах, маргаан шийдвэрлэх комисс томилогдон ажиллаж байна. 6 сард багтаан ЗГ-аар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Газар дээр нь томилолтоор ажилласан. Мөн УУ-н Сайд, БОНХАЖ-ын Сайд нарын 97/А-227 тоот тушаалаар хамтарсан Ажлын хэсэг ажиллаж байна.</p> <p>Биелэлт- 70%</p>	70

7	7	<p>Хөрөнгө гаргах тухай 2015-04-20</p> <p>1 Гацууртын алтны ордыг ашигласны улмаас Төв аймгийн Борнуур сумын нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Хүннүгийн үеийн Бороогийн сууринд үзүүлж болзошгүй нөлөөллийг судалж, мэргэжлийн дүгнэлт гаргахад зориулан 57,241,000.0 (тавин долоон сая хоёр зуун дөчин нэгэн мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбатад зөвшөөрч, орд ашиглалтад орсон тохиолдолд уг хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэхийг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгасугай.</p>	БХЗГ	Гацууртын орд ашиглалтад ороогүй байна. /Хугацаа болоогүй/	/-/
8	8	<p>Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл цуцлах, зөвшөөрөл олгох тухай 2015-09-07</p> <p>1 Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт орших Түйн голын алтны шороон ордын XV-003595, XV-004211 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцлахыг Ашигт малтмалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Үүрийнтуяад даалгасугай.</p>	БХЗГ	Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт орших Түйн голын алтны шороон ордын XV-003595, XV-004211 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцалсан. /хаах саналтай./	100 %
	9	<p>Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл цуцлах, зөвшөөрөл олгох тухай 2015-09-07</p> <p>3 "Монголросцветмет" ХХК-ийн хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцлах, компанид шинээр тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгасугай.</p>	БХЗГ	Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-нь өдрийн 511 дүгээр тогтоолоор "Монголросцветмет" ХХК-д хамаарах талбайг оруулж тус компани-д шинээр тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулан олгосон. Биелэлт:100%	100 %
9	10	<p>Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын тухай 2015-12-21</p> <p>3 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тухай бүр нийтэд мэдээлэн ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Ашигт малтмалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Үүрийнтуяа нарт үүрэг болгосугай.</p>	ГБГ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тухай бүр нийтэд мэдээлж, /104 дүгээр уртрагаас баруун болон зүүн тийш/ ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлын явцад орон нутгийн удирдлагын зүгээс ихээхэн хүндрэл учруулж байгаа тул Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаар авах үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлага үүссэн. Иймд хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаар 2016 онд олгогдоогүй.	100 %

10	11	<p>Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай 2016-08-03</p> <p>3 Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах хуулийн этгээдэд хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нарт даалгасугай.</p>	ГБГ		/-/
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ					
1	1	<p>2015 оны 03 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2015-03-16</p> <p>XIII. 4.1. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгох ажлын явцын талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Засгийн газрын хуралдаанд хийх танилцуулгыг нэг загварт оруулан, 7 хоногийн хугацаанд гарсан өөрчлөлтийг харуулах боломжтой байдлаар бэлтгэн танилцуулж байхыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд;</p>	ГБГ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлын журмын дагуу зохион байгуулсан бөгөөд 2015 оны байдлаар нийт 9 багцаар 87 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явагдаж 37 талбайд Хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон байна. Уг ажлаас улсын төсөвт 10.1 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Биелэлт-100% хаах саналтай байна.	100 %
		<p>2015 оны 01 дүгээр сарын 19-н өдөр 04 дүгээр тэмдэглэл 2015-01-19</p> <p>XI. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологийн судалгааны ажлын үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p>		3.1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын явц, хэрэгжилт, үр дүнгийн талаар 2016 оны 1-р улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар материал бэлтгэж удирдлагад танилцуулсан. 3.2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн талбайг /2008 болон 2009/ улсын нөөцөөс чөлөөлөх асуудлыг судалж саналыг удирдлагад танилцуулсан. АМТХ-ын 13-р зүйлд заасны дагуу нөөцөд байх хугацаа дууссан тул нөөцөөс чөлөөлөгдсөн. 3.3. Геологийн судалгааны ажлын үр дүнд тогтоогдсон ашигт малтмалын хэтийн төлөв бүхий эрдсийн хуримтлалтай А, Б зэрэглэлийн талбайг ялган хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох жагсаалтад оруулан ажилласан.	

2	2	<p>Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав:</p> <p>3.1. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын явц, үр дүнг жил бүр Засгийн газарт танилцуулж байх;</p> <p>3.2. улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн талбайг улсын нөөцөөс чөлөөлөх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж байх;</p> <p>3.3. геологийн судалгааны ажлын үр дүнд тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж байх.</p>	ГБГ		100 %
3	3	<p>2016 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр 24 дугаар тэмдэглэл 2016-04-25</p> <p>ХҮ.7. 2. "Нью Коже" ХХК-ийг төрийн өмчийн оролцоотой "Арева майнс" ХХК-д нэгтгэсэнтэй холбогдуулан Дулаан уул, Зөөвч овоо, Өмнөд зэрэг цацраг идэвхт ашигт малтмалын ордын MV-018914, MV-018915, MV-018916 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэрийг "Эрдэнэс Монгол" ХХК-иас санал авсны үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрчлөхийг Ашигт малтмалын газрын дарга Д.Үүрийнтуяад даалгав.</p>	УУБГ	<p>Цөмийн энергийн комиссоос Дулаан уул, Зөөвч овоо, Өмнөд зэрэг цацраг идэвхт ашигт малтмалын ордын MV-018914, MV-018915, MV-018916 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл шилжүүлэхтэй холбоотойгоор Кожеговь ХХК-ийг өөрчлөн байгуулах тухай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдөр батламжилсан бөгөөд МУ-ын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны 24-р тэмдэглэлд "Эрдэнэс Монгол" ХХК-аас санал авсныг үндэслэн "Аревамайнс" ХХК-ийн нэр дээр бүртгэхийг даалгах шийдвэр гарсан.</p> <p>Дээрх шийдвэрүүдийн дагуу MV-018914, MV-018915, MV-018916 дугаартай тусгай зөвшөөрлүүдийг АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 24 дүгээр шийдвэрээр Нью Коже ХХК-аас Арева майнс ХХК-ийн нэр дээр шилжүүлэн бүртгэсэн.</p>	100 %